



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Гадаад харилцааны яам 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** САГ-2019/261/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

(Хотын нэр оруулах)

2019 он

Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261585

Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням

Утас: 261885

Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Аудитор:

Л.Хонгорзул

Утас: 260512

Цахим хаяг: khongorzull@audit.gov.mn

Аудитор:

Л.Мөнхцацрал

Утас: 260512

Цахим хаяг: munkhtsatsrall@audit.gov.mn

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДТГ	Дипломат төлөөлөгчийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан .....	5
2.1.	Оршил .....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	11
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал .....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
	СТ-1А .....	14
	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	16
	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	18
	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	21
	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	22
5.	<b>Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....</b>	<b>25</b>

## 1 Аудитын гэрчилгээ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/238  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Д.ДАВААСҮРЭН ТАНАА

#### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гадаад харилцааны яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Гадаад харилцааны яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гадаад харилцааны яамны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Kherregl\Yawsan\_Bichig\2019\0225SAG4.Docx


070550

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Гадаад харилцааны яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гадаад харилцааны яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаад харилцааны яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Л.Хонгорзул, аудитор Л.Мөнхцацрал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Гадаад харилцааны яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Гадаад харилцааны яамны 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 08/409 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулийн хугацаанд ирүүлсэн байна.



### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Гадаад харилцааны яамны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Гадаад харилцааны яам нь “Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд олон улсын таатай гадаад орчныг бүрдүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгыг биелүүлэхдээ “Монгол Улсын гадаад харилцааг үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон зарчим, чиглэлээр улс орны болон дэлхий дахины улс төр, эдийн засгийн шинэ нөхцөл байдалтай уялдуулан тууштай хэрэгжүүлж, үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг идэвхтэй явуулах, гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг эрхэмлэж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр суурийг бэхжүүлэх, гадаад эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тууштай явуулах зорилтуудыг удирдлага болгоно” гэж үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах таатай гадаад орчныг бүрдүүлэх;
- Монгол Улсын хөгжлийг хангах таатай гадаад орчныг бүрдүүлэх;
- Монгол Улсын иргэдийн эрх ашиг, бизнесийн ашиг сонирхлыг хилийн чанадад хамгаалах зэрэг болно.

Гадаад харилцааны яамны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Гадаад харилцааны яамны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Гадаад харилцааны яамны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Гадаад харилцааны яам санхүүгийн тайланг бэлтгэхдээ ГҮҮК СОФТ ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн “Axplorer 3.16” програм хангамж ашигладаг байна.

Гадаад харилцааны яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.



## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Гадаад харилцааны яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт орлогын дүнгээс тооцоход их байгаатай холбоотой юм.

Гадаад харилцааны яамны 2018 оны нийт зардал 12,805,442.3 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 256,108.85 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй

асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	92,833.1	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	330.4	
3	Албан шаардлага өгсөн	1	105,699.3	
	Дүн	5	198,862.8	

**2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай Засгийн газрын 2016 оны 3 дугаар тогтоолоор Гадаад харилцааны яамны орон тооны дээд хязгаарыг 142 хүнээр баталсан байхад 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 151 ажилтан буюу 11 орон тоо илүү ажиллуулж ойролцоогоор 105,699.3 мянган төгрөгийн цалингийн зардал гаргасан, орон тоог хэтрүүлснээс жилийн эцэст батлагдсан цалингийн зардал хүрэлцэхгүй төсөвт 100,000.0 мянган төгрөгийн зохицуулалт хийлгэсэн зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалт болон ЗГ-ын 2016 оны 3 дугаар тогтоолын холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай ЗГ-ын 2016 оны 3 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

2. Гадаад харилцааны яам нь 2018 онд албан тушаалын болон албан ажлын хэрэгцээнд автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан болох сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарт 330.4 мянган төгрөгийн унааны мөнгө давхардуулан олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2015 оны "Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 184 дүгээр тогтоолтой нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан ажлын хэрэгцээнд автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтнуудад давхардуулан олгосон 330.4 мянган төгрөгийн унааны мөнгийг төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

**2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Гадаад харилцааны яамны аппаратын санхүүгийн програмд хамт бүртгэгдсэн Олон Улсын хамтын ажиллагааны сан, Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн 2017 оны санхүүгийн тайланг төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамруулан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

ГХЯ-ны “Ёслол хүндэтгэлийн өргөө”-ний барилга угсралтын ажил дуусч 2017 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан боловч анхны гүйцэтгэгч болох "Хөмөтэ" ХХК-тай барилгын гүйцэтгэлийн талаар маргаан үүсгэсэн шүүхийн асуудал эцэслэгдээгүй байгаа тул улсын комиссын акт гараагүй, санхүүгийн тайлангийн дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй хэвээр байна.

## **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Гадаад харилцааны яам чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 9 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 11,452,139.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 7,413,761.5 мянган төгрөг буюу 65.8 хувьтай байгаа нь мэдээлэл технологийн үйлчилгээг сайжруулах зориулалтаар 990,000.0 мянга, тэтгэвэрт гарахад нэг удаагийн тэтгэмж олгох 148,786.7 мянган төгрөг батлагдсаныг тус тус зарцуулаагүй, Олон Улсын хамтын ажиллагааны сангийн зардалд 990,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 116,717.4 мянган төгрөг зарцуулсан, мөн Засгийн газрын гадаад шилжүүлгийн зардалд 2,969,776.8 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 42.7 хувь буюу 1,266,911.0 мянган төгрөгийг зарцуулсан зэргээс шалтгаалжээ.

Засгийн газрын гадаад шилжүүлгийн зардалтай холбоотой ямар нэгэн өр төлбөр тайлагнаагүй бөгөөд энэ нь 2018 оны Засгийн газрын гадаад шилжүүлгийн зардлын төлөвлөгөөг үндэслэл муутай хэт өндрөөр баталсантай холбоотой байна.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 560,000.0 мянган төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр 387.3 хувийн биелэлттэй буюу 1,609,196.4 мянган төгрөгөөр давж биелсэн байна. Энэ нь 2018 оны үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг үндэслэл муутай хэт багаар баталсантай холбоотой байна.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Гадаад харилцааны яам нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Гадаад харилцааны яам Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn)/Гадаад харилцааны яам цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2018 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг 369 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 9 зөвлөмж өгсний 7 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн байна.

Тайлант оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар өглөг барагдуулах талаар өгсөн зөвлөмж тээвэр шатахууны зардал дууссанаас Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газарт төлөх тээврийн зардлыг төлөх боломжгүй болж өр төлбөр нэмэгдсэн, санхүүгийн тайланд дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй байгаа “Ёслол хүндэтгэлийн өргөө”-ний улсын комиссын акт шүүхийн маргаантай асуудлаас шалтгаалан эцэслээгүй байгаа тул дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй хэвээр байгаа зэргээс шалтгаалж зөвлөмжийн хэрэгжилт 77.8 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Гадаад харилцааны яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Гадаад харилцааны яамны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Гадаад харилцааны яамны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1. “Балансын данстай холбоотой асуудал”

##### 3.1.1. Илрүүлэлт

Тайлант онд бараа материал, үнэт цаасны тайланг сар бүр гаргаагүй, хагас бүтэн жилээр 2 удаа гаргасан, тайланг хянаж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т *“Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”* гэсэн заалттай нийцэхгүй, Гадаад харилцааны яамны НБББББ-ийн 4.1.6 дахь заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

##### 3.1.2. Эрсдэл

Бараа материал, үнэт цаасны дутагдах, анхан шатны бүртгэл дутуу хөтлөгдөх

##### 3.1.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НБББББ-ийн холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөв.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг В501 маягтаар хураангуйлан Гадаад харилцааны яамны удирдлагад танилцуулахад алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

### 3.2. “Балансын данстай холбоотой асуудал”

#### 3.2.1. Илрүүлэлт

Гадаад оронд суугаа ДТГ-уудад олгодог визийн хуудасны тооцоог хоорондын тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д *“Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мөрдөнө”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### 3.2.2. Эрсдэл

Үнэт цаас дутагдах, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл зөрүүтэй хөтлөгдөх

#### 3.2.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, 2019 оноос визийн хуудасны тооцоог төвийн ДТГ-т шилжүүлж, бүртгэл тооцоог НББОУС-ын дагуу хөтөлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг В501 маягтаар хураангуйлан Гадаад харилцааны яамны удирдлагад танилцуулахад алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

### 3.3. “Балансын данстай холбоотой асуудал”

#### 3.3.1. Илрүүлэлт

Тайлант онд өглөг 92,833.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д *“төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### 3.1.2. Эрсдэл

Төсөв захирагч Төсвийн тухай хуулиар хүлээсэн үүргийг биелүүлэхгүй байх

#### 3.1.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, Төсвийн тухай хуулийг мөрдөж, авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах талаар зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг В501 маягтаар хураангуйлан Гадаад харилцааны яамны удирдлагад танилцуулахад алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**4 Аудит хийсэн санхүүгийн тайлан**

**СТ-1А**

**Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>936,507,292.01</b>	<b>552,761,923.39</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	1,755,738.24	4,306,191.00
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	1,675,738.24	0.00
31110	Төгрөг	1,675,738.24	0.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>80,000.00</b>	<b>4,247,191.00</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	80,000.00	4,247,191.00
31211	Төрийн сангийн харилцах		4,237,191.00
31213	Арилжааны банк дахь харилцах	80,000.00	10,000.00
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө		59,000.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>488,357,260.28</b>	<b>327,936,645.75</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	23,938,912.61	
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	464,418,347.67	327,936,645.75
3351	Байгууллагаас авах авлага	384,486,665.96	287,418,704.02
3352	Хувь хүмүүсээс авах авлага	79,931,681.71	40,517,941.73
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>59,275,548.00</b>	<b>32,966,000.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	59,275,548.00	32,966,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>387,118,745.49</b>	<b>187,553,086.65</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	353,399,521.58	140,804,743.74
35110	Тусгай зориулалттай материал	353,399,521.58	140,804,743.74
